



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

хххх/ оны хх сарын хх өдөр

Дугаар хххх

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Цагдаагийн эргүүлийн машин худалдан авах” ажлын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог зөвшилцсөнөөр дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Э.Баярмагнай

(Газрын даамал)

Нарийн бичгийн дарга:

Б.Базаррагчаа

(Хөдөлмөр, халамж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

С.Сүрэнжаргал

(Шивээ Овоо хувьцаат компанийн Төлөвлөлтийн эдийн засагч)

Ё.Батцэнгэл

(Шивээ Овоо хувьцаат компанийн Тээвэр үйлчилгээний хэсгийн механик)

Хөндлөнгийн төлөөлөл:

Б.Эрдэнэбаяр

(Шивээ Овоо хувьцаат компанийн Техникийн бодлогын хэлтсийн дарга)

2. “Цагдаагийн эргүүлийн машин худалдан авах” ажлын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хариуцлагатай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны дарга /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ